

**“РАШААНТ ДАХЬ УЛСЫН НӨӨЦИЙН АГУУЛАХ ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
КОНЦЕССЫН ГЭРЭЭ (БАРИХ-ӨМЧЛӨХ-АШИГЛАХ) ВОО”-НД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ НЭМЭЛТ ГЭРЭЭ**

2020 оны 4 дүгээр  
сарын 2-ны өдөр

Улаанбаатар  
хот

Энэхүү “Рашаант дахь улсын нөөцийн агуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээ (барих-өмчлөх-ашиглах) ВОО”-нд өөрчлөлт оруулах тухай нэмэлт гэрээ /цаашид “Нэмэлт гэрээ” гэх/-г Концессын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 119 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөрөнгө оруулалтын газар болон “Нэйшнл трейдинг энд транспорт групп” ХХК нарын хооронд 2015 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр байгуулагдсан “Рашаант дахь улсын нөөцийн агуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээ (барих-өмчлөх-ашиглах) ВОО” /цаашид “Концессын гэрээ” гэх/-ний 4.5 дахь хэсэг болон Нэйшнл трейдинг энд транспорт групп ХХК-иас ирүүлсэн 2020 оны 02/020, 03/20 дугаар албан тоот хүсэлтүүдийн дагуу,

Нэг талаас Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газар /цаашид “Эрх бүхий этгээд” гэх/-ын дарга Б.Баярсайхан,

Нэгөө талаас “Нэйшнл трейдинг энд транспорт групп” ХХК (РД: 5837014) /цаашид “Концесс эзэмшигч” гэх/, түүнийг төлөөлөн Ерөнхий захирал Л.Нямсүрэн нар Концессын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахаар харилцан тохиролцож байгуулав.

**НЭГ. НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ**

- 1.1. “Рашаант дахь улсын нөөцийн агуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээ”-ний 1.7-д “56 сар” гэснийг “72 сар” гэж,
- 1.2. “Рашаант дахь улсын нөөцийн агуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээ”-ний 1.9<sup>1</sup>-д “56 сар” гэснийг “72 сар” гэж тус тус өөрчлөн найруулав.

**ХОЁР. БУСАД**

- 2.1. Энэхүү Нэмэлт гэрээгээр өөрчлөлт оруулсанас бусад Концессын гэрээний зохицуулалт нь хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.
- 2.2. Нэмэлт гэрээ нь адил хүчинтэй 3 хувь үйлдэгдсэн бөгөөд талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж Концессын гэрээний салшгүй хэсэг болсон гэж үзнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
  
Гарын үсэг: .....  
  
Нэр: Б.Баярсайхан  
Албан тушаал: Үндэсний хөгжлийн  
газрын дарга  
  
Тамга

КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
  
Гарын үсэг: .....  
  
Нэр: Л.Нямсүрэн  
Албан тушаал: Ерөнхий захирал  
  
Тэмдэг